



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/024/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан Утас:99163087, Цахим хаяг: shurtkhairkhaniikhishigaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5.1Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв .....	11
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	19
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	20

#### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Д.БУЯНХҮҮ ТАНАА

2026.02.15 № УВА-2026/024/НА-СПА-ТЦЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050176

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>167,085,417.65</b>	<b>211,010,555.20</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,413,560.41	27,192,784.98
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,413,560.41	27,192,784.98
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,413,560.41	27,192,784.98
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	4,413,560.41	27,192,784.98
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	54,951,922.79	47,520,340.63
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	499,991.15
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	53,143,101.36	46,993,349.48
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,808,821.43	27,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,808,821.43	27,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	103,306,374.04	131,883,869.18
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	21,618,515.24	28,054,973.24
35130	Эм боох материал	21,618,515.24	28,054,973.24
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	81,687,858.80	103,828,895.94
35410	Бичиг хэргийн материал	2,472,200.00	2,932,400.00
35420	Аж ахуйн материал	55,872,075.44	81,470,075.44
35430	Сэлбэг хэрэгсэл	1,403,000.00	1,403,000.00
35450	Барилгын засварын материал	5,938,650.00	5,938,650.00
35460	Хүнсний материал	7,233,572.36	3,316,409.50
35470	Бусад хангамжийн материал	8,768,361.00	8,768,361.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>855,291,296.83</b>	<b>901,913,073.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	855,291,296.83	901,913,073.91
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	834,251,296.83	880,873,073.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	608,764,291.11	608,764,291.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,596,726.54	-69,161,464.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	206,328,571.43	201,828,571.43
39204	Хуримтлагдсан элэгдэл	-89,788,928.41	-94,484,642.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	166,490,147.90	252,439,057.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,289,462.05	-118,592,607.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,120,937.00	110,337,937.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,706,066.74	-56,171,833.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	87,660,715.00	89,610,715.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-26,732,181.87	-43,696,948.60
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	21,040,000.00	21,040,000.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,040,000.00	21,040,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,017,963,154.07</b>	<b>1,108,510,068.70</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,821,768.67</b>	<b>46,828,214.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	12,821,768.67	46,828,214.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	12,821,768.67	46,828,214.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	21,176,091.08
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	12,821,768.67	25,652,122.92
41361	Байгууллагад төлөх өглөг	12,821,768.67	24,632,122.92
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,020,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,005,141,385.40</b>	<b>1,061,681,854.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,005,141,385.40	1,061,681,854.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,956,542.95	245,956,542.95
51101	Өмч: - төрийн	245,956,542.95	245,956,542.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	433,422,646.80	489,963,116.10
51210	Өмнөх үеийн үр дүн	327,685,662.88	438,878,532.66
51220	Тайлант үеийн үр дүн	105,736,983.92	51,084,583.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	325,762,195.65	325,762,195.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,017,963,154.07</b>	<b>1,108,510,068.70</b>

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>545,601,486.63</b>	<b>1,362,625,672.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,371,769.00</b>	<b>92,654,722.52</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	10,371,769.00	92,654,722.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	1,834,313.42
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	1,834,313.42
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>535,229,717.63</b>	<b>1,269,970,949.56</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	17,373,464.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	17,373,464.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	8,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,400,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	27,120,000.00	34,776,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,120,000.00	34,776,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	508,109,717.63	1,209,420,585.56
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	508,109,717.63	1,209,420,585.56
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>480,447,663.82</b>	<b>1,311,541,088.64</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>480,447,663.82</b>	<b>1,311,541,088.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	480,443,743.31	1,311,156,088.64
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	368,124,015.41	826,399,566.59
210101	Үндсэн цалин	320,673,946.48	438,577,543.77
210102	Нэмэгдэл	00.00	296,776,475.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	28,380,000.00
210104	Урамшуулал	46,124,010.68	62,665,547.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,326,058.25	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,670,641.81	104,080,892.00
210201	Тэтгэврийн даатгал	32,429,653.81	71,152,592.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,222,433.00	8,232,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,778,040.00	4,116,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	555,607.00	4,116,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,684,908.00	16,464,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,116,588.18	52,642,722.29
210301	Гэрэл, цахилгаан	4,279,811.98	12,819,169.95
210302	Түлш, халаалт	19,836,776.20	39,823,552.34
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	537,000.00	54,688,030.00
210401	Бичиг хэрэг	00.00	4,072,850.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	35,096,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	1,803,330.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,000.00	13,715,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,764,880.00	118,746,848.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,764,880.00	78,569,486.00
210502	Хоол, хүнс	00.00	40,177,362.86

**Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	25,326,951.88
210602	Тавилга	00.00	6,149,751.88
210604	Урсгал засвар	00.00	19,177,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,696,000.00	7,376,000.00
210702	Дотоод албан томилолт	3,696,000.00	7,376,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,098,000.00	19,715,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	18,163,464.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	477,000.00	375,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	118,896.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	196,065.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	55,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,436,617.91	102,179,952.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	892,000.00	685,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,544,617.91	101,494,132.02
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,920.51</b>	<b>385,000.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,920.51</b>	<b>385,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,920.51	385,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>65,153,822.81</b>	<b>51,084,583.44</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>65,153,822.81</b>	<b>51,084,583.44</b>

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,215,934,699.97</u></b>	<b><u>1,271,805,262.98</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>35,235,692.00</b>	<b>1,834,313.42</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	35,235,692.00	1,834,313.42
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	35,235,692.00	1,834,313.42
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,235,692.00	00.00
120004 3	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	1,834,313.42
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,180,699,007.97</b>	<b>1,269,970,949.56</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	17,373,464.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	17,373,464.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	8,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,400,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	49,761,700.00	34,776,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,761,700.00	34,776,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,130,937,307.97	1,209,420,585.56
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,130,937,307.97	1,209,420,585.56
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,138,948,399.26</u></b>	<b><u>1,249,026,038.41</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,138,948,399.26</b>	<b>1,249,026,038.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,120,952,278.75</b>	<b>1,248,641,038.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	743,109,720.26	809,898,261.41
210101	Үндсэн цалин	401,889,766.75	418,297,752.59
210102	Нэмэгдэл	288,181,984.58	300,554,961.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,587,900.00	28,380,000.00
210104	Урамшуулал	46,124,010.68	62,665,547.27
210105	Гэрээт ажлын хөлс	1,326,058.25	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	113,049,799.00	100,386,900.00
210201	Тэтгэврийн даатгал	83,715,499.00	67,458,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,333,500.00	8,232,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,666,800.00	4,116,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,666,800.00	4,116,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,667,200.00	16,464,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,257,779.49	32,526,900.00
210301	Гэрэл, цахилгаан	9,190,699.12	7,560,174.44
210302	Түлш, халаалт	37,222,080.37	24,966,725.56
210303	Цэвэр, бохир ус	845,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	58,202,000.00	50,717,230.00
210401	Бичиг хэрэг	4,146,650.00	4,072,550.00
210402	Тээвэр, шатахуун	38,306,850.00	35,096,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,538,000.00	1,803,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,495,000.00	1,625,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,715,500.00	8,120,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	121,579,580.00	132,724,402.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,848,380.00	89,336,702.00
210502	Хоол, хүнс	36,551,200.00	30,802,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,180,000.00	12,585,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,801,600.00	36,635,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	380,000.00	3,050,000.00

**Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	23,421,600.00	28,585,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,982,000.00</b>	<b>6,356,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,982,000.00	6,356,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,685,100.00</b>	<b>19,997,445.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,780,000.00	17,937,464.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	477,000.00	375,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,500.00	226,961.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	388,000.00	395,000.00
210807	Газрын төлбөр	591,600.00	168,320.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,284,700.00</b>	<b>1,118,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,284,700.00	1,118,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,996,120.51</b>	<b>385,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,992,200.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,992,200.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,920.51</b>	<b>385,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,920.51	385,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>76,986,300.71</b>	<b>22,779,224.57</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>72,656,000.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>72,656,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>72,656,000.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	72,656,000.00	58,280,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-72,656,000.00</b>	<b>-58,280,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>4,330,300.71</b>	<b>22,779,224.57</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>83,259.70</b>	<b>4,413,560.41</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,413,560.41</b>	<b>27,192,784.98</b>

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>245,956,542.95</b>	<b>325,762,195.65</b>	<b>221,520,548.13</b>	<b>793,239,286.73</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>245,956,542.95</b>	<b>325,762,195.65</b>	<b>221,520,548.13</b>	<b>793,239,286.73</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	106,165,114.75	106,165,114.75
8	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>245,956,542.95</b>	<b>325,762,195.65</b>	<b>433,422,646.80</b>	<b>1,005,141,385.40</b>
9	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>245,956,542.95</b>	<b>325,762,195.65</b>	<b>433,422,646.80</b>	<b>1,005,141,385.40</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
11	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>245,956,542.95</b>	<b>325,762,195.65</b>	<b>433,422,646.80</b>	<b>1,005,141,385.40</b>
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	51,084,583.30	51,084,583.30
17	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>245,956,542.95</b>	<b>325,762,195.65</b>	<b>484,507,230.10</b>	<b>1,056,225,968.70</b>

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,231,641,000.00</b>	<b>1,214,249,138.41</b>	<b>17,391,861.59</b>	<b>99%</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,231,641,000.00</b>	<b>1,214,249,138.41</b>	<b>17,391,861.59</b>	<b>99%</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,231,641,000.00</b>	<b>1,214,249,138.41</b>	<b>17,391,861.59</b>	<b>99%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>810,009,300.00</b>	<b>809,898,261.41</b>	<b>111,038.59</b>	<b>100%</b>
210101	Үндсэн цалин	510,430,600.00	418,297,752.59	92,132,847.41	82%
210102	Нэмэгдэл	228,645,200.00	300,554,961.55	(71,909,761.55)	131%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,554,200.00	28,380,000.00	(20,825,800.00)	376%
210104	Урамшуулал	63,379,300.00	62,665,547.27	713,752.73	99%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>100,386,900.00</b>	<b>100,386,900.00</b>	<b>-</b>	<b>100%</b>
210201	Тэтгэврийн даатгал	67,458,600.00	7,458,600.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	8,232,100.00	8,232,100.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,116,000.00	4,116,000.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,116,000.00	4,116,000.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	16,464,200.00	16,464,200.00	-	100%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>58,487,000.00</b>	<b>50,717,230.00</b>	<b>7,769,770.00</b>	<b>87%</b>
210401	Бичиг хэрэг	4,653,000.00	4,072,550.00	580,450.00	88%
210402	Тээвэр, шатахуун	39,209,200.00	35,096,350.00	4,112,850.00	90%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,895,200.00	1,803,330.00	1,091,870.00	62%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,136,000.00	1,625,000.00	2,511,000.00	39%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,593,600.00	8,120,000.00	(526,400.00)	107%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>133,297,800.00</b>	<b>132,724,402.00</b>	<b>573,398.00</b>	<b>100%</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,131,600.00	89,336,702.00	(1,205,102.00)	101%
210502	Хоол, хүнс	32,561,000.00	30,802,700.00	1,758,300.00	95%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,605,200.00	12,585,000.00	20,200.00	100%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>99,225,900.00</b>	<b>93,050,900.00</b>	<b>6,175,000.00</b>	<b>94%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	54,571,400.00	51,930,000.00	2,641,400.00	95%
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,400,000.00	600,000.00	94%

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,392,000.00</b>	<b>6,356,000.00</b>	<b>36,000.00</b>	<b>99%</b>
210702	Дотоод албан томилолт	6,392,000.00	6,356,000.00	36,000.00	99%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,947,900.00</b>	<b>2,623,981.00</b>	<b>2,323,919.00</b>	<b>53%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,783,600.00	564,000.00	1,219,600.00	32%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	714,200.00	375,300.00	338,900.00	53%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,000.00	226,961.00	43,039.00	84%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	88,000.00	62,000.00	59%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,700.00	395,000.00	78,700.00	83%
210807	Газрын төлбөр	750,000.00	168,320.00	581,680.00	22%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,520,700.00</b>	<b>1,118,000.00</b>	<b>402,700.00</b>	<b>1,520,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,520,700.00	1,118,000.00	402,700.00	1,520,700.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,373,500.00</b>	<b>17,373,464.00</b>	<b>36.00</b>	<b>100%</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,373,500.00	17,373,464.00	36.00	100%
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,256,413,935.04</b>	<b>1,209,420,585.56</b>	<b>46,993,349.48</b>	<b>96%</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,256,413,935.04</b>	<b>1,209,420,585.56</b>	<b>46,993,349.48</b>	<b>96%</b>
310001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,256,413,935.04	1,209,420,585.56	46,993,349.48	96%
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		<b>1,834,313.42</b>		
350001	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс		8,400,000.00		
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>4,413,560.41</b>		
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>27,192,784.98</b>		

**2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/**

10	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	34,776,900.00	34,391,900.00	385,000.00	99%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	34,776,900.00	34,391,900.00	385,000.00	99%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	34,776,900.00	34,391,900.00	385,000.00	99%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,526,900.00	32,526,900.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	6,305,200.00	7,560,174.44	(1,254,974.44)	120%
210302	Түлш, халаалт	25,903,300.00	24,966,725.56	936,574.44	96%
210303	Цэвэр, бохир ус	318,400.00	318,000.00	-	100%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,250,000.00	1,865,000.00	385,000.00	83%
210604	Урсгал засвар	2,250,000.00	1,865,000.00	385,000.00	83%
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>34,776,900.00</b>	<b>34,391,900.00</b>	<b>385,000.00</b>	<b>99%</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>34,776,900.00</b>	<b>34,391,900.00</b>	<b>385,000.00</b>	<b>99%</b>
320001	Орон нутгийн төсвөөс	34,776,900.00	34,391,900.00	385,000.00	99%

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90,546.9 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,413.6	27,192.8	22,779.2
Авлага	54,951.9	47,520.3	-7,431.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	103,306.4	131,883.9	28,577.5
Үндсэн хөрөнгө	855,291.3	901,913.1	46,621.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,017,963.2</b>	<b>1,108,510.1</b>	<b>90,546.9</b>
Өр төлбөр	12,821.8	46,828.2	34,006.4
Засгийн газрын хувь оролцоо	1,005,141.4	1,061,681.9	56,540.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,017,963.2</b>	<b>1,108,510.1</b>	<b>90,546.9</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 27,192.8 мянган төгрөг болж 22,779.2 мянган төгрөгөөр өссөн нь энэ оны төсвөөс хэмнэж ажилласантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 47,520.3 мянган төгрөг болж, 7,431.6 мянган төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага 6,149.7 мянган төгрөгөөр буурч ажиллагсадтай холбогдсон авлага 499.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 131,883.9 мянган төгрөг болж 28,557.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 6,436.85 мянган төгрөг, бичиг хэргийн материал 460.2 мянган төгрөг, аж ахуйн материал 25,598.0 мянган төгрөгөөр өсч, хүнсний материал 3,917.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 901,913.1 мянган төгрөг болж, 46,621.8 мянган төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл 4,500.0 мянган төгрөгөөр буурч, тоног төхөөрөмж 85,948.9 мянга, тавилга эд хогшил 30,127.0 мянга, бусад үндсэн хөрөнгө 1,950.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 70,444.1 мянган төгрөг гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 46,828.2 мянган төгрөг болж, 34,006.4 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбогдсон өглөг 21,176.1 мянга, байгууллагад төлөх өглөг 11,810.3 мянга, хувь хүмүүст төлөх өглөг 1,020.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,061,681.9 мянган төгрөг болж 56,540.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,231,641.0 мянга, орон нутгийн төсвөөс 45,210.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,276,851.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,256,413.9 мянга, орон нутгийн төсвөөс 34,776.9 мянга, нийт 1,291,190.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 40 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,256,413.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 34,779.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,209,420.6 мянга, орон нутгийн төсвөөс 34,776.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагаанаас 1,834.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 25,773.5 мөнгөн төгрөг бүрдүүлж нийт урсгал үйл ажиллагаанд 1,271,805.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,271,805.3 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь энэ оны төсвөөс хэмнэж ажилласантай холбоотой байна.

**Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл/Улсын төсөв/*

*/мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	746,483.10	746,225.08	258.02	100%
2	81603	үндсэн мэргэжлийн тусламж үйлч	509,930.80	463,195.50	46,735.30	91%
		<b>ДҮН</b>	<b>1,256,413.90</b>	<b>1,209,420.58</b>	<b>46,993.32</b>	<b>96%</b>

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөв/*

*/мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	34,776.90	34,391.90	385.0	99%
		<b>ДҮН</b>	<b>34,776.90</b>	<b>34,391.90</b>	<b>385.0</b>	<b>99%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

*/мянган төгрөгөөр/*

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл, тайлагнал	0.0	0.0	Санхүүгийн программ 2018 онд 440.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь программы хангамж дансанд бүртгэлтэй байна. Тайлант онд шинээр програм хангамж аваагүй.
2	Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф	7,554.2	28,380.0	Дотоод журамд заасны дагуу нэг хүнд 1 өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	0.0	Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.

**Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0.0	0.0	Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудад төлбөр төлөөгүй байна.
---	--	-----	-----	--

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Увс аймгийн Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Увс аймгийн Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 221,723.1 мянган төгрөгийн бараа материалын шууд худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,311,541.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,115.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 10,492.4 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 31 мэдээллээс хугацаандаа оруулсан 29, хоцроож мэдээлсэн 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 980.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

### 5.1. Төлбөрийн акт

1. Эрүүл мэндийн төвийн дарга Д.Буянхүүд ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоосон.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрүүл мэндийн төвийн дарга Д.Буянхүүд ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон	1	980.3	1	980.3								
Дүн	1	980.3	1	980.3								

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн утга	Зөрчлийн товч	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/



**БЭЛТГЭСЭН:**

**“ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ” ХХК-ийн АУДИТОР**

/С.БАТСАЙХАН/



2026 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр

БАТЛАВ.  
УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТӨРГҮҮДЭХ  
АУДИТОР М.БАТСУУРЬ



Улаангом

2026 оны 02-р сарын 15

№.....

## МЭДЭГДЭЛ

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн  
дарга Д.Буянхүү, нягтлан бодогч Ж.Ичинноров нарт  
сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Эрүүл мэндийн төвийн дарга Д.Буянхүүд ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн акт тогтоохоор болсон тул Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 27.4.2 дахь заалтад заасны дагуу "саналыг бичгээр авах" хэлбэрээр сонсох ажиллагаа явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагааны мэдэгдэлтэй танилцаж хариу тайлбарыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн албан бичгээр ирүүлнэ үү.

Мэдэгдлийг бэлтгэсэн: "Шүрт хайрханы хишиг аудит" ХХК-ийн  
аудитор

С.Батсайхан

Хянасан: Аудитын менежер

М.Бат-Амгалан



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/06/В2715686  
УВА-2026/024/НА-СТА-ТШЗ

Улаангом

### ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн дарга Д.Буянхүүд ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 980.3 мянган төгрөгийн ээлжийн амралтын цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон ээлжийн амралтын цалин 980 276 (есэн зуун наян мянга хоёр зуун далан зургаан) төгрөгийг төлүүлж, Төрийн сан дахь МХГ-ын орлогын 1000150000982 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Хяргас сумын Засаг дарга В.Сайнбилэгт хариуцуулав.

<sup>1</sup> Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

8525110036

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөргүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн  
АУДИТОР

С.БАТСАЙХАН

